

Бүлэг 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1 Нийтлэг үндэслэл, судалгааны зорилго

Авлигатай тэмцэх газрын дарга болон Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 06-р сарын 23-ны өдрийн 76/ (01/69) тоот хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан “Авлигын индекс тооцох аргачлал”-ын дагуу Авлигын индексийг тооцох үндсэн мэдээллийг цуглуулах зорилго бүхий судалгааны нэг нь Шинжээчдийн төсөөллийн судалгаа юм.

Шинжээчдийн төсөөллийн судалгааны зорилго нь тодорхой нутаг дэвсгэр (аймаг, нийслэл), төрийн захиргааны байгууллага (яам, агентлаг) дахь авлигын цар хүрээ, авлигын хэлбэр, шалтгаан, эдийн засгийн хор уршиг зэргийг тодорхой шалгуураар сонгосон шинжээчдээр үнэлүүлэхэд оршиж байсан юм.

Шинжээчдийн төсөөллийн судалгаанд дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлэн ажилласан. Үүнд:

1. Салбарын авлигын төлөв байдал, авлигатай тэмцэх үйл ажиллагааны хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх шинжээчдийн багийг бүрдүүлэх,
2. Шинжээчдээс Авлигын индексийг тооцоход шаардлагатай мэдээллийг цуглуулж, авлигын индексийг тоцон гаргах,
3. Салбарын авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааны талаар болон авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, үйл ажиллагааны хүрсэн түвшинг шинжээчдээр үнэлүүлэн, цаашдын бодлого, үйл ажиллагааг төлөвлөх зэрэг байв.

Тухайн салбарт ажиллаж байгаа, салбарын үйл ажиллагааны талаар өргөн мэдлэг, мэдээлэлтэй төрөл бүрийн төлөөллийг хамарсан шинжээчдээр салбарын авлигын төлөв байдал, цар хүрээ, хэлбэр, шалтгаан болон салбарын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, үйл ажиллагааны хүрсэн түвшинг үнэлүүлж, дүгнэн шинжлэх замаар авлигатай үр өгөөжтэй тэмцэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг төлөвлөхөд энэхүү судалгааны ач холбогдол оршиж байсан юм.

1.2 Судалгааны хамрах хүрээ

Шинжээчдийн төсөөллийн судалгааны хамрах хүрээг үнэлэх салбарын хувьд ерөнхийд нь дараахь байдлаар ангилж авч үзсэн. Үүнд:

- Төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, тэдгээрийн орон нутаг дахь салбар нэгж
- Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага
- Шүүх, прокурорын байгууллага

Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага гэдэгт Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай Монгол Улсын хуулийн 9 болон 33 дугаар зүйлд заасан аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын ажлын алба буюу Засаг даргын тамгын газрыг хамруулан авч үзсэн. Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагыг аймаг, нийслэлийн түвшинд ангилан авч үзэж судалгааны үр дүнг гаргасан.

Төрийн захиргааны төв байгууллагыг Засгийн газрын тухай Монгол Улсын хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу дараахь байдлаар ангилж авч үзсэн. Үүнд:

1. Сангийн сайдын эрхлэх асуудлын
2. Гадаад хэргийн сайдын эрхлэх асуудлын
3. Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын
4. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын
5. Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын
6. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын
7. Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын
8. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын
9. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын
10. Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын
11. Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын

Үүн дээр Тэргүүн шадар сайд болон Шадар сайдын эрхлэх асуудлын төрийн захиргааны байгууллагуудыг нэгтгэн “Шадар сайдын эрхлэх асуудлын” гэсэн нэг бүлэгт оруулж авч үзсэн.

Дээрх ангиллын дагуу төрийн захиргааны байгууллага буюу агентлаг, тэдгээрийн аймаг, нийслэл дэх салбар нэгжүүд үндсэн салбартаа харъяалагдаж үнэлэгдсэн.

Прокурорын байгууллага гэдэгт Прокурорын байгууллагын тухай Монгол Улсын хуулийн 2 дугаар зүйлд заасан Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий, үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагыг ерөнхийд нь авч үзэж, уг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу Улсын ерөнхий прокурорын газар, аймаг, нийслэлийн прокурорын газар, сум буюу сум дундын, дүүргийн прокурорын газрыг хамруулан авч үзсэн.

Шүүхийн байгууллага гэдэгт Шүүхийн тухай Монгол Улсын хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасны дагуу Монгол Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхийг хамруулан авч үзсэн.

1.3 Судалгааны ерөнхий зарчим, зохион байгуулалт, мэдээлэл цуглуулалт

Шинжээчдийн төсөөллийн судалгаа нь авлигын индексийг тооцох, авлигатай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг төлөвлөхөд шаардлагатай мэдээллийг цуглуулах чухал ач холбогдолтой судалгаа бөгөөд судалгааны мэдээллийн үнэн бодитой байдлыг хангах үүднээс судалгаанд дараахь зарчмыг баримтлан ажилласан. Үүнд:

- Тухайн салбар болон аймаг, нийслэлийн төрийн байгууллагын үйл ажиллагааг дотроос болон хөндлөнгөөс үнэлэх бүхий л чиглэлийн төлөөллийг оролцуулсан байх,
- Тухайн салбар болон аймаг, нийслэлийн төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдлэг, мэдээлэлтэй, ажлын туршлагатай, судалгаанд үнэн зөв мэдээлэл өгч чадахуйц шинжээчдийг сонгосон байх,
- Шинжээчдийн талаарх болон тэдний өгсөн мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах,
- Судалгааны асуулга, зааварт нийтээр хүлээн зөвшөөрсөн эсвэл ойлгогдохуйц тайлбарлагдсан нэр томъёог ашигласан байх зэрэг болно.

Судалгааны зохион байгуулалтын дараалал нь дараахь байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

- Судалгааны зохион байгуулагч тал буюу Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний алба,
- Шинжээчид буюу шинжээчдийн төсөөллийн судалгаанд оролцуулахаар сонгосон судалгаанд оролцогчид.

Судалгааг зохион байгуулагч тал буюу АТГ-ын США нь судалгаанд оролцох шинжээчдийг сонгох, шинжээчдийг асуулга, заавраар хангах, судалгааны аргачлал, аргазүйн талаар зөвлөгөө өгч ажиллах, судалгааны ажлыг зохион байгуулж явуулан үр дүнг нэгтгэн гаргах үүргийг гүйцэтгэн ажилласан. Шинжээчид нь зохион байгуулагч талаас хүлээлгэн өгсөн асуулга, зааврын дагуу мэдээллийг гаргаж хүлээлгэн өгөх үүргийг гүйцэтгэсэн.

Судалгааг дараахь дарааллын дагуу хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Судалгаанд оролцох шинжээчдэд зар тарааж, судалгаанд оролцох хүсэлтэй шинжээчдийн материалыг хүлээн авах;
2. Холбогдох шалгуураар судалгааны хамрах хүрээнд судалгаанд оролцуулах шинжээчдийн жагсаалтыг гаргах;
3. Шинжээчидтэй холбогдож судалгаанд оролцох талаар зөвшөөрлийг авах;
4. Шинжээчдэд судалгааны асуулга, зааврыг хүргүүлж танилцуулах;

5. Шинжээчидтэй холбогдож судалгааны асуулга, зааврыг хэрхэн ойлгосныг нягталж ойлголтын зөрүүг засварлах;
6. Шинжээчдээс асуулгыг бөглүүлж авах;
7. Шинжээчдээс мэдээллийг хүлээн авч шалгаж, шаардлагатай тохиолдолд асууж тодруулан, холбогдох засвар өөрчлөлтийг хийх;
8. Мэдээллийг кодлох, шивж оруулах;
9. Судалгааны үр дүнгийн хүснэгтүүдийг боловсруулан гаргах;

Судалгааны үр дүнг авлигын индексийг тооцоход ашиглах, үр дүнгийн танилцуулга, тайлан бичих зэрэг ажлууд хийгдсэн болно.

1.4 Судалгааны хугацаа

Судалгааны мэдээллийг 2009 оны 11 дүгээр сарын 18-наас 12 дугаар сарын 1-нийг хүртэлх хугацаанд цуглуулсан.

1.5 Судалгааны түүвэрлэлт

Шинжээчдийн төсөөллийн судалгаанд нийтдээ 350 шинжээч оролцоно гэж тооцсон. Эдгээр шинжээчид нь 13 салбарын (11 яам, Шадар сайдын эрхлэх асуудлын болон шүүх, прокурорын салбар) болон 22 аймаг, нийслэлийн нийтдээ 35 салбарыг үнэлэх бөгөөд нэг салбарыг дунджаар 10 шинжээч үнэлэх юм. Тухайн салбарыг үнэлэх шинжээчдийн тоо нь салбарын үйл ажиллагааны цар хүрээ, хамрах хүрээнээс шалтгаалан янз бүр байх болно.

Шинжээчдийн төсөөллийн судалгааны удирдамжид заасны дагуу шинжээчээр дараахь байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөллийг хамруулна. Үүнд:

1. Шүүх, Прокурорын байгууллага болон тухайн салбарын төрийн захиргааны төв байгууллага буюу яам, агентлаг, тэдгээрийн орон нутаг дахь салбар нэгж тус бүрээс
2. Аймаг, нийслэлийн ИТХ, Засаг даргын тамгын газар, сум, дүүргийн ИТХ, Засаг даргын тамгын газар тус бүрээс, түүнчлэн баг, хорооны Засаг дарга нараас түүвэрлэх байдлаар
3. Аймаг, нийслэлийн ИТХ, Засаг даргын тамгын газар, сум, дүүргийн ИТХ, Засаг даргын тамгын газрын хяналт, шалгалт хариуцсан ажилтнуудаас түүвэрлэх байдлаар
4. Тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж, нутгийн захиргааны байгууллагуудтай 6 жилээс доошгүй хугацаагаар ямар нэг байдлаар хамтран ажилладаг аж ахуйн нэгжүүд
5. Тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж, нутгийн захиргааны байгууллагуудтай ямар нэг байдлаар хамтран ажилладаг Төрийн бус байгууллагууд
6. Тухайн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг, салбарын яам, агентлагуудтай холбогдож ажилладаг аж ахуйн нэгжүүд

7. Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд
8. Шүүх, Прокурорын байгууллага болон тухайн салбарт үйл ажиллагаа явуулж төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буй, салбарын яам, агентлагуудтай холбогдож ажилладаг Төрийн бус байгууллагууд
9. Тухайн салбарын чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийдэг эрдэмтэн, судлаачдаас
10. Шүүх, Прокурорын байгууллагын чиглэлээр болон тухайн салбарт судалгаа хийдэг судлаачид гэх мэт.

1.6 Судалгааны асуулгын хуудас

Шинжээчдийн төсөөллийн судалгааны асуулгыг боловсруулахдаа Транспэрэнси Интернэшнл олон улсын байгууллагын захиалгаар Галлоп судалгааны байгууллагаас жил бүр явуулдаг Дэлхий нийтийн Авлигын барометрийн судалгааны асуулга, Мянганы хөгжлийн зорилт 9-д хүрэхэд дэмжлэг үзүүлэх төслийн баг, АТГ хамтран боловсруулсан улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгаанд ашигладаг асуулгын хуудсын ерөнхий загвар зэрэгт үндэслэсэн бөгөөд энэ бүх асуулгууд нь Монгол улсын нөхцөлд туршигдсан зэрэг нь дээрх асуулгуудыг практикт шууд ашиглаж болох юм гэж үзсэн.

Судалгааны асуулгад авлигын индексийн тооцоонд шаардлагатай мэдээллээс гадна авлигын шалтгаан, цар хүрээний талаарх мэдээлэл буюу судалгаагаар авах шаардлагатай мэдээллийг бүрэн багтаасан бөгөөд тухайн салбарын үйл ажиллагааны талаар илүү нарийн мэдээлэл авах байдлаар тодорхойлсон.

Судалгааны асуулгуудыг бөглөх зааварт ерөнхий судалгааны зорилго, ач холбогдол, хамрах хүрээ, зохион байгуулалтын асуудлыг танилцуулж өгсөн нь ихээхэн чухал ач холбогдолтой болсон гэж үзэж байгаа болно.

Судалгааны удирдамжинд судалгааны үндэслэл, зорилго, зарчим, хамрах хүрээ, ажлын бэлтгэл, зохион байгуулалт, хугацаа, түүвэрлэлт, судалгаанаас гарах үр дүн зэргийг оруулсан.

1.7 Мэдээлэл боловсруулалт

Судалгааны мэдээллийг оруулах загварыг АНУ-ын Тооллогын товчооноос боловсруулсан CPro 4.0 (Census and Survey Program) программ дээр боловсруулсан. Энэхүү программаар мэдээлэл оруулах үеийн шалгалтуудыг дараахь байдлаар хийсэн.

1. Мэдээлэл оруулах явцад хариултыг оруулахгүй өнгөрөх явдлаас сэргийлэх үүднээс хариулт байх ёстой асуулт бүр дээр хариултыг заавал оруулахыг сануулахаар (хэрэв тухайн асуултад үнэхээр хариулаагүй байх тохиолдолд алгасахаар) программыг боловсруулан мэдээллийг оруулсан.
2. Асуултын хариултад байхгүй кодуудыг оруулахад анхааруулах, оруулсан утга нь тодорхой хязгаарт багтахгүй байх тохиолдолд анхааруулахаар программыг боловсруулан мэдээллийг оруулсан. Тухайлбал, төрийн албан хаагчдын насны хязгаарыг 18-65 гэж тодорхойлж өгсөн бөгөөд

хэрэв 16 гэсэн утга оруулбал “Хязгаараас гадуурх утга оруулсан байна. Шалгана уу”

3. Асуулт хоорондын энгийн уялдаа холбоо, үсрэлт зэргийг оруулах программын дагуу шалгасан.

Оруулах программын дагуу мэдээллийг оруулж дууссны дараа CPro 4.0 программын Batch Edit хэрэгслийг ашиглан алдааг олж илрүүлэхэд дараах шалгалтуудыг хийсэн. Үүнд:

- Ердийн шалгалт: бүх асуулт бүрэн хариулагдсан эсэхийг шүүж шалгах, үсрэлт зөв байгааг шалгах шалгалт;
- Үнэмшилтэй утгийн шалгалт: байж болох утгаас давсан онцгой утга байгаа эсэхийг шалгах шалгалт;
- Статистик анализд тулгуурлагдсан хамаарлын болон логик шалгалт: утгуудын хоорондын уялдаа, логик холбоо, утгуудын нийлбэр нийт дүнтэй тэнцүү эсэх шалгалт;
- Мэдээлэл оруулах программын шалгалт: Үүнд ердийн шалгалт, үнэмшилтэй утга болон хамаарлын шалгалтууд;
- Мэдээлэл шалгах программын шалгалт: Мэдээлэл оруулах программын шалгалт, дээр нь нэмэлт шалгалтууд;

Мэдээллийг оруулж дууссны дараа CPro 4.0 программын Export Data хэрэгслийг ашиглан SPSS 16.0 (Statistical Package for the Social Sciences) программ руу хөрвүүлсэн. Мэдээллийн баазыг бэлтгэсний дараа баазаас энгийн давтамжийн хүснэгтүүдийг гаргаж мэдээллийг дахин шалгаж холбогдох засвар, өөрчлөлтийг хийсэн.

SPSS 16.0 программыг ашиглан үр дүнгийн хүснэгтүүдийг гарган авч тайланг бэлтгэхэд ашигласан.

Авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн судалгааны мэдээлэл нь 99 хувьсагчтай байсан.

Бүлэг 2. АВЛИГЫН ТАЛААРХ ШИНЖЭЭЧДИЙН ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГААНЫ СУДАЛГААНЫ ДҮН

2.1 Судалгааны ерөнхий дүн

Авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн 2009 оны судалгаанд 21 аймаг, 14 салбарын 347 шинжээч оролцлоо. Судалгаанд оролцогчдын 156 нь буюу 45.0 хувь нь нийслэл Улаанбаатар хотоос, үлдсэн 191 буюу 55.0 хувь нь аймгуудаас хамрагдсан байна. Судалгаанд оролцсон нийт шинжээчдийн 6.6 хувь нь төрийн төв байгууллага буюу яамнаас, төрийн захиргааны байгууллага буюу агентлагаас 11.8 хувь, төрийн захиргааны байгууллагын орон нутаг дахь салбар нэгжээс 14.1 хувь, нутгийн өөрөө удирдах байгууллагаас 3.5 хувь нь, нутгийн захиргааны байгууллагаас 19.9 хувь нь, шүүх, прокурорын байгууллагаас 8.4 хувь нь, 18.7 хувь нь аж ахуйн нэгж, байгууллага, үлдсэн 17.0 хувь нь төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, олон улсын байгууллага, тэдгээрийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж, судалгаа, шинжилгээний байгууллага, судлаачдын төлөөлөл байв.

Судалгаанд оролцсон нийт шинжээчдийн 49.0 хувь нь эрэгтэй, 51.0 хувь нь эмэгтэй байна. Судалгаанд оролцогчдын 8.6 хувь нь магистр, 1.7 хувь нь боловсролын болон шинжлэх ухааны доктор цолтой байна.

Шинжээчдийн хувьд авлигын талаар илүү дэлгэрэнгүй мэдлэгтэй, мэдээлэлтэй хүмүүс бөгөөд тэднээр Монгол улс дахь болон үнэлж буй салбар дахь авлигын тархац, одоогийн төр засгийн авлигатай тэмцэх үйл ажиллагааны үр өгөөжийг үнэлүүлсэн юм. Судалгаанд оролцсон шинжээчдийн 51.0 хувь одоогийн төр засгийн авлигатай тэмцэх үйл ажиллагааг үр ашигтай байна гэж үнэлсэн бол 24.8 хувь үр ашиггүй байна, 20.2 хувь үр ашигтай ч биш, үр ашиггүй ч биш байна гэж үнэлжээ. Түүнчлэн нийт шинжээчдийн 72.3 хувь нь авлига Монгол улсад түгээмэл гэж үзсэн бол 22.5 хувь нь дунд зэрэг, 3.5 хувь нь бага зэрэг байна гэж үзжээ.

Үнэлж буй салбар, төрийн байгууллагуудын түвшинд авлига түгээмэл гэж нийт шинжээчдийн 40.6 хувь нь үзсэн бол 31.7 хувь нь дунд зэрэг, 21.6 хувь нь бага зэрэг, 2.3 хувь нь огт байхгүй гэж үзжээ. Шинжээчдийн үзэж байгаагаар авлига хамгийн түгээмэл тархсан салбаруудад Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын (авлига түгээмэл гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь 69.0 хувь), Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын (авлига түгээмэл гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь 53.8 хувь), Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын (авлига түгээмэл гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь 50.0 хувь) төрийн байгууллагууд орж байна. Шинжээчдийн төсөөллөөр авлигад хамгийн их автсан нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудад Орхон (авлига түгээмэл гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь 80.0 хувь), Архангай (авлига түгээмэл гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь 71.4 хувь), Баян-Өлгий, Хэнтий (авлига түгээмэл гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь 62.5 хувь), Өмнөговь (авлига түгээмэл гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь 60.0 хувь) аймгуудын нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагууд орж байна.

2.2.2 Салбарын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл зоригийн шинжилгээ

Авлигатай тэмцэхэд төрийн байгууллагын удирдлагууд авлигатай тэмцэх хүсэл зоригтой байхаас шууд шалтгаална. Судалгаанаас үзэхэд төрийн захиргааны, шүүх, прокурорын байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын удирдлагуудын 11.2 хувь нь авлигатай тэмцэх хүсэл зориггүй гэж үнэлэгдсэн бол 43.2 хувь нь удирдлагын авлигатай тэмцэх хүсэл зориг сул, зарим нэг ажил төлөвлөдөг боловч хэрэгжилт нь хангалтгүй, хэрэгжилтэнд нь хяналт тавьдаггүй, 38.0 хувь нь авлигатай тэмцэх хүсэл зориг дунд зэрэг, төлөвлөсөн ажлуудынх нь биелэлт, тэдгээрт тавигдах хяналт дунд зэрэг, 7.5 хувь нь авлигатай тэмцэх хүсэл зориг сайн, тодорхой ажил төлөвлөж, хэрэгжүүлж, хянаж чаддаг гэж үнэлэгджээ. Шүүх, прокурорын байгууллагын байгууллагыг үнэлсэн шинжээчдийн 42.9 хувь нь, Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагыг үнэлсэн шинжээчдийн 16.7 хувь нь, Сангийн сайдын болон Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагыг үнэлсэн шинжээчдийн 15.4 хувь нь, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагыг үнэлсэн шинжээчдийн 7.7 хувь нь, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх төрийн байгууллагыг үнэлсэн шинжээчдийн 7.1 хувь нь, Шадар сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлсэн 6.3 хувь нь, Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлсэн шинжээчдийн 5.6 хувь, нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудыг үнэлсэн шинжээчдийн дүнгээр 3.6 хувь нь тухайн салбар, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын удирдлагууд авлигатай тэмцэх чиглэлээр тодорхой ажлыг төлөвлөж, хэрэгжүүлж, хянаж чаддаг гэж үнэлжээ. Үүний дотор Орхон аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагыг үнэлсэн шинжээчдийн 20.0 хувь нь, Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагыг үнэлсэн шинжээчдийн 14.3 хувь нь, Сүхбаатар, Хэнтий аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагыг үнэлсэн шинжээчдийн 12.5 хувь нь, нийслэл Улаанбаатар хотын нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагыг үнэлсэн шинжээчдийн 10.0 хувь нь тухайн аймаг, нийслэлийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын удирдлагууд авлигатай тэмцэх чиглэлээр тодорхой ажлыг төлөвлөж, хэрэгжүүлж, хянаж чаддаг гэж үнэлжээ.

Салбарын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл зоригийн тоон үнэлгээний дундаж нь 1.4 гарч байна. Удирдлага нь авлигатай тэмцэх хүсэл зориггүй гэж үнэлсэн тохиолдолд 0, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл зориг сул, зарим нэг ажил төлөвлөдөг боловч хэрэгжилт нь хангалтгүй, хэрэгжилтэнд нь хяналт тавьдаггүй гэж үнэлсэн тохиолдолд 1, авлигатай тэмцэх хүсэл зориг дунд зэрэг, төлөвлөсөн ажлуудынх нь биелэлт, тэдгээрт тавигдах хяналт дунд зэрэг гэж үнэлсэн тохиолдолд 2, авлигатай тэмцэх хүсэл зориг сайн, тодорхой ажил төлөвлөж, хэрэгжүүлж, хянаж чаддаг гэж үнэлсэн тохиолдолд 3 гэсэн тоон үзүүлэлтээр үнэлсэн болно. Тэгэхээр нийт төрийн захиргааны байгууллагууд, шүүх, прокурорын байгууллагууд, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын дунджаар авлигатай тэмцэх хүсэл зоригийн үнэлгээ дундаас доогуур байна. Авлигатай тэмцэх хүсэл зоригийн үнэлгээ Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагууд (0.9), Байгаль орчин аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагууд (1.3), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагууд (1.3), Нутгийн захиргааны болон өөрөө удирдах

байгууллагууд (1.3), Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагууд (1.4), Шадар сайдын эрхлэх асуудлын (1.4) төрийн байгууллагууд дунджаас доогуур буюу дунджийн түвшинд буюу удирдлагын авлигатай тэмцэх хүсэл зориг сул талдаа, зарим нэг ажил төлөвлөдөг боловч хэргжүүлэлт сул, хяналт тавьдаггүй гэж үнэлэгдэж байна. Сангийн сайдын эрхлэх асуудлын (1.5), Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын (1.5), Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын (1.5), Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын (1.6), Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын (1.6), Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын (1.8) төрийн байгууллагуудад авлигатай тэмцэх хүсэл зоригийн үнэлгээ 1.5-1.8 буюу удирдлагын авлигатай тэмцэх хүсэл зориг уднд зэрэг, төлөвлөсөн ажлуудын биелэлт, хяналт дунд зэрэг байна гэж үнэлэгджээ.

Авлигатай тэмцэх хүсэл зоригийн үнэлгээ аймаг, нийслэлийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын дунджаар 1.3 буюу удирдлагын авлигатай тэмцэх хүсэл зориг сул талдаа байна гэж шинжээчид үнэлжээ. Дорноговь аймаг (1.9), Сүхбаатар аймаг (1.8), Улаанбаатар нийслэл (1.7), Дорнод, Төв, Орхон, Говьсүмбэр (1.6) аймгуудын нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл зориг нийт нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын дунджаас дээгүүр буюу авлигатай тэмцэх хүсэл зориг дунд түвшинд ойролцоо байна гэж үнэлэгджээ.

Удирдах албан тушаалтнууд авлигатай тэмцэх ажлыг ажилтан, албан хаагчдаас шаардах бус өөрсдөө үлгэр дууриал болж манлайлан оролцох нь илүү үр дүнтэй. Салбарын удирдлагууд нь авлигатай тэмцэх чиглэлээр байнга ярьдаг, уриалдаг гэдэгтэй нийт шинжээчдийн 11.5 хувь нь санал бүрэн нийлж байна гэж хариулсан бол 47.0 хувь нь зарим талаараа нийлнэ, 41.5 хувь нь огт нийлэхгүй байна гэж хариулжээ. Салбарын удирдлагууд нь авлигатай тэмцэх чиглэлээр байнга ярьдаг, уриалдаг гэдэгтэй ямар нэг байдлаар санал нийлж байна гэж хариулсан шинжээчдийн эзлэх хувь Шүүх, прокурорын байгууллага (85.7 хувь), Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын (71.4 хувь), Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын (69.2 хувь), Шадар сайдын эрхлэх асуудлын (68.8 хувь) төрийн байгууллагуудад өндөр байгаа бол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын (35.7 хувь) болон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын (46.7 хувь) төрийн байгууллагуудад доогуур байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын болон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудын удирдлагын талаас бага хувь нь авлигатай тэмцэх чиглэлээр ярьдаг, уриалдаг байна. Удирдах албан тушаалтнууд нь авлигатай тэмцэх чиглэлээр хамгийн их ярьдаг, уриалдаг аймгуудаар Дорнод (85.7 хувь), Сэлэнгэ (85.7 хувь), Орхон (80.0 хувь), Баянхонгор (75.0 хувь), Өвөрхангай аймгууд тодорч байгаа бол Баян-Өлгий (12.5 хувь), Булган (20.0 хувь), Архангай (28.6 хувь), Говь-Алтай (33.3 хувь), Хэнтий (37.5 хувь), Өмнөговь (20.0 хувь), Ховд (42.9 хувь) аймгуудын нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын удирдлагуудын талаас бага хувь нь энэ талаар ярьдаг уриалдаг гэж үнэлэгджээ.

Ярьж уриалж байгаа нь хэрхэн ажил хэрэг болж байгааг судалгаанд оролцогчид дараах байдлаар дүгнэжээ. Шинжээчдийн төсөөллийн судалгаанд оролцогчдын 32.0 хувь нь салбарын удирдах төв байгууллага нь авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөөтэй, 36.9 хувь нь ийм төлөвлөгөө байдаггүй гэж үзсэн бол 31.1 хувь энэ талаар мэдэхгүй гэж хариулжээ. Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлсэн шинжээчдийн 66.7 хувь нь, Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлсэн шинжээчдийн 55.6 хувь, Сангийн сайдын эрхлэх асуудлын турийн байгууллагуудыг үнэлсэн шинжээчдийн 53.8 хувь нь уг салбарт авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө буюу авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авах арга хэмжээний талаарх төлөвлөгөөтэй гэж хариулсан байна. Энэ удаагийн судалгаанд салбарыг үнэлэх шинжээчдээр тухайн салбарын төрийн захиргааны төв байгууллага, орон нутаг дахь салбар нэгжүүдийн төлөөллөөс гадна тухайн салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буй олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, судлаачдын төлөөллийг оролцуулсан бөгөөд судалгаанд тухайн салбарын удирдах дээд байгууллага нь авлигаас урьдчилан сэргийлэх стратеги төлөвлөгөөтэй байсан хэдий ч шинжээчид тухайн салбарт тухайн салбарт энэ төрлийн төлөвлөгөө байддаггүй гэж үнэлсэн байгаа нь стратеги төлөвлөгөөгөө сурталчилдаггүй, энэхүү төлөвлөгөө нь тунхаглалын шинж чанартай, нэр төдий, түүнчлэн доод шатны байгууллагууддаа хүрдэггүй гэж дүгнэж болох юм. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлсэн шинжээчдийн 60.0 хувь уг салбарт энэ чиглэлийн төлөвлөгөө байдаг талаар мэдэхгүй гэж хариулсан бөгөөд тэдэнд энэ талаар мэдэх боломж олдоогүй байна. Судалгаанд оролцож буй шинжээчдэд, хэрэв тухайн шинжээч судалгаанд дурдсан асуудлаар тодорхой мэдээлэл байхгүй байгаа тохиолдолд энэ төрлийн мэдээллийг олж авч, түүндээ үнэлэлт дүгнэлт өгөх шаардлагыг тавьсан.

Харин Орхон аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагыг үнэлж буй шинжээчдийн 80.0 хувь нь, Дорнод аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагыг үнэлж буй шинжээчдийн 57.1 хувь нь, Говь-Алтай, Увс аймаг, нийслэл Улаанбаатар хотын нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагыг үнэлж буй шинжээчдийн 50.0 хувь нь авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөөтэй буюу авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авах арга хэмжээний талаарх төлөвлөгөөтэй гэж хариулжээ. Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудын дунджаар 26.9 хувь нь ийм төрлийн төлөвлөгөөтэй, 44.3 хувь нь төлөвлөгөө байхгүй гэж үнэлэгдсэн болон нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагыг үнэлж буй шинжээчдийн 28.7 хувь нь энэ талаар мэдэхгүй гэж хариулжээ. Булган аймгийн шинжээчдийн 60.0 хувь нь, Дундговь аймгийн шинжээчдийн 62.5 хувь нь, Төв аймгийн шинжээчдийн 80.0 хувь нь энэ талаар мэдэхгүй гэж хариулсан бас нэг анхаарал татахуйц асуудал юм.

Салбарт авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө байдаг гэж хариулсан шинжээчдээр уг стратеги төлөвлөгөөний үр өгөөжийг үнэлүүлэхэд Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж байгаа шинжээчид бүгд уг стратеги төлөвлөгөөг үр өгөөжгүй гэж үнэлжээ. Харин бусад салбарын шинжээчдийн 50.0-85.7 хувь нь ямар нэг байдлаар үр өгөөжтэй гэж үнэлжээ. Салбарын авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй

байж чаддаггүй шалтгааныг Шадар сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлсэн шинжээчид төлөвлөгөө нь цаасан дээр нэр төдий зүйл байдаг, түүнийг ажил хэрэг болгох хүсэл эрмэлзэл удирдлагуудад дутдаг, төлөвлөгөөний зорилго чиглэлийг сайтар сурталчилж үр дүнг танилцуулдаггүй, үр дүнг нь үнэлэх шалгуур байдаггүйтэй холбон тайлбарлажээ.

Сангийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн хувьд салбарын авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө нь үр ашигтай байдаггүйг хариуцах эзэн тодорхойгүй, хөрөнгө мөнгө төсөвлөдөггүй, албан хаагчдаас санал авдаггүй, бодит боломжоос давсан зүйлсийг төлөвлөдөг зэрэг шалтгаантай холбон тайлбарлажээ. Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудын хувьд удирдлагын зүгээс дэмжлэг муутай байдаг, стратеги төлөвлөгөө нь нэгждээ хүрдэггүй, хэрэгжүүлэх арга зам нь буруу байдгаас нь уг төлөвлөгөө нь үр дүнд хүрдэггүй байна. Бусад салбаруудын хувьд дээр дурдсан шалтгаан нийтлэг давтагдаж байна.

Аймаг, нийслэлийн нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудын хувьд авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө нь үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгааныг шинжээчид төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьдаггүй, хяналт тавих боломж муу, цаасан бичигдсэн тунхаглалын шинж чанартай, улс төрийн нөлөө их байдаг, тогтмол бус цаг үеийн шинжтэй, сурталчилгаа сайн хийгддэггүй, хэрэгжүүлэх хүсэл зориг сул, судалгаа, шинжилгээнд үндэслэгдээгүй байдагтай холбон тайлбарлажээ.

Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр салбарын хэмжээнд хөрөнгө мөнгө төсөвлөдөг үү гэсэн асуултад судалгаанд оролцсон шинжээчдийн 2.6 хувь нь хангалттай мөнгө төсөвлөдөг, 22.2 хувь нь төсөвлөдөг боловч шаардлагатай хэмжээнд бус, 42.4 хувь нь огт төсөвлөдөггүй гэж хариулсан бол 32.9 хувь нь мэдэхгүй гэжээ. Үүний дотор Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн 83.3 хувь нь, Шадар сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн 50.0 хувь, нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагыг үнэлж буй шинжээчдийн 47.3 хувь нь, бусад салбарыг үнэлж буй шинжээчдийн 22.2-46.2 хувь нь энэ чиглэлээр хөрөнгө мөнгө огт төсөвлөдөггүй гэж хариулжээ. Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудын хувьд Архангай, Баянхонгор, Булган, Ховд, Хөвсгөл аймгуудад авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хөрөнгө мөнгө огт төсөвлөдөггүй гэж үнэлэгдсэн бол бусад аймаг, нийслэлийн хувьд ямар нэг байдлаар хөрөнгө мөнгө төсөвлөдөг гэж үнэлжээ.

Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулагддаг хэлэлцүүлэгт салбарын шийдвэр гаргах түвшний албан тушаалтнууд идэвхтэй сайн оролцдог гэж нийт шинжээчдийн 21.9 хувь нь үзсэн бол 55.6 хувь нь оролцохоосоо оролцохгүй байх нь их байдаг, 8.6 хувь нь огт оролцдоггүй, 13.8 хувь нь энэ талаар мэдэхгүй байна гэж хариулжээ. Шүүх, прокурорын байгууллагын удирдлагууд (нийт шинжээчдийн 57.1 хувь нь) хамгийн идэвхтэй сайн оролцдог гэж үнэлсэн бол Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудын удирдлагууд энэ төрлийн ажилд огт оролцдоггүй (нийт шинжээчдийн 37.5 хувь нь) эсвэл оролцохоосоо оролцохгүй байх нь их (нийт шинжээчдийн 62.5 хувь нь) гэж үнэлэгджээ. Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын удирдлагуудын хувьд Орхон аймгийн (нийт шинжээчдийн 80.0 хувь нь) удирдлагууд идэвхтэй сайн үнэлэгдсэн бол Булган,

Өмнөговь аймгийн шинжээчид бүгд нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын удирдлагууд нь энэ төрлийн ажилд оролцохоосоо оролцохгүй байх нь их гэж үнэлэгджээ.

Нийт судалгаанд оролцсон шинжээчдийн 8.6 хувь нь үнэлж буй салбарт удирдах албан тушаалтны томилгоо хийхэд мэргэшсэн байдал, шударга зарчимч байдал хамгийн гол шалгуур болдог гэж үзсэн бол 36.9 хувь нь зарим тохиолдолд шалгуур болох нь бий гэж, 54.5 хувь нь огтхон ч шалгуур болдоггүй гэж хариулжээ. Төрийн захиргааны байгууллага, шүүх прокурорын байгууллагын, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын удирдах албан тушаалтны томилгооны талаас илүү хувьд нь мэргэшсэн, шударга зарчимч байдал огтхон шалгуур болдоггүй өөр бусад хүчин зүйлс нөлөөлдөг байна. Шүүх прокурорын байгууллагыг үнэлсэн шинжээчдийн 28.6 хувь нь эдгээр нь хамгийн гол шалгуур болдог гэж үзсэн бол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудад албан тушаалтны томилгоонд мэргэшсэн байдал, шударга зарчимч байдал огтхон ч шалгуур болдоггүй гэж шинжээчдийн 71.4 хувь нь, Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагыг үнэлсэн шинжээчдийн 61.7 хувь нь үзжээ.

Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудын удирдах албан тушаалтны томилгоо хийхэд мэргэшсэн байдал, шударга зарчимч байдал шалгуур үзүүлэлт болж чаддаг эсэхийг аймгуудаар авч үзэхэд Архангай, Өмнөговь, Орхон аймагт уг байдал огтхон ч шалгуур болдоггүй гэж тухайн аймгуудыг үнэлж буй шинжээчид бүгд санал нэг үзжээ.

Салбарын удирдах албан тушаалтны томилгоо хийхэд мэргэшсэн байдал, шударга зарчимч байдал гол шалгуур үзүүлэлт болдоггүй бөгөөд улс төрийн намын харъяаллыг гол болгож үздэг гэдэгтэй нийт шинжээчдийн 86.8 хувь нь санал нийлж байгаа бөгөөд уг үзүүлэлтийг салбаруудаар авч үзэхэд 50.0-100 хувьтай байна. Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын, Батлан хамгаалах сайдын эрхлэх асуудлын, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчид бүгд улс төрийн намын харъяаллаар удирдах албан тушаалтны томилгоог хийдэг гэж үзжээ. Танил тал, садан төрлийн холбооны хувьд нийт шинжээчдийн 75.1 хувь нь удирдах албан тушаалтын томилгоог хийхэд дээрх шалгуурыг голчлон үздэг гэдэгтэй санал нийлж байгаа бөгөөд үүнийг салбараар нь авч үзэхэд 28.6-100.0 хувьтай байна. Сангийн сайдын эрхлэх асуудлын, Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын, Батлан хамгаалах сайдын эрхлэх асуудлын, Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчид бүгд танил тал, садан төрлийн холбоо гол шалгуур болдог гэж үзсэн бол Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн 28.6 хувь нь уг байдал байдаг гэдэгтэй санал нийлж байна гэжээ. Авлига хээл хахууль удирдах албан тушаалтны томилгоонд гол шалгуур болдог гэж нийт шинжээчдийн 42.9 хувь нь хувь нь үзсэн бол уг үзүүлэлтийг салбараар авч үзэхэд тухайн салбарыг үнэлж буй шинжээчдийн 14.3-62.5 хувь нь нь тухайн салбарын удирдах албан тушаалтны томилгоо хийхэд авлига, хээл хахууль гол шалгуур болдог гэж үзжээ. Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчид авлига, хээл хахууль удирдах албан тушаалтны томилгоонд огт нөлөөлдөггүй гэж үзсэн бол Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын

төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдын 66.7 хувь авлига хээл хахууль уг салбарт удирдах албан тушаалтны томилгоонд авлига, хээл хахууль голлон нөлөөлдөг гэж үзжээ.

Харин нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудын хувьд Архангай, Баянхонгор, Дорноговь, Дорнод, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Хөвсгөл, Орхон аймгуудад улс төрийн намын харъяаллаар удирдах албан тушаалтны томилгоог хийдэг гэдэгтэй шинжээчид бүгд санал нийлсэн бол Баянхонгор, Булган, Дорнод, Дундговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр аймгуудад танил тал, садан төрлийн холбоогоор удирдах албан тушаалтны томилгоог хийдэг гэдэгтэй шинжээчид бүгд санал нийлж байна гэжээ. Харин Говь-Алтай, Дорнод аймгуудын шинжээчид бүгд албан тушаалтны томилгоог авлига, хээл хахуулиар шийддэг гэж үзжээ.

Нийт шинжээчдийн дунджаар 33.4 хувь нь үнэлж буй салбарын удирдах албан тушаалтнуудын дотор ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан гэж үзсэн бол 50.7 хувь нь дунд зэрэг тархсан, 13.3 хувь нь тун бага тархсан, 2.6 хувь нь огт тархаагүй гэж үзжээ. Шинжээчдийн үзэж байгаагаар удирдах албан тушаалтнуудын дунд ашиг сонирхлын зөрчил тун их тархсан салбар бол Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын (50.0 хувь), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын (50.0 хувь), Сангийн сайдын эрхлэх асуудлын (46.2 хувь), Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын (44.4 хувь), Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын (36.4 хувь) төрийн байгууллагууд юм. Ашиг сонирхлын зөрчил тун их тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувийг 75.0 хувиар, дунд зэрэг тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувийг 50.0 хувиар, тун бага тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувийг 25.0 хувиар, огт тархаагүй гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувийг 0.0 хувиар үнэлэн тухайн салбар дахь ашиг сонирхлын зөрчлийн тархцын дундаж хувийг тооцож үзвэл нийт салбаруудын дунджаар 51.6 хувь болж байна. Ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан салбараар 59.6 хувиар Сангийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагууд, 58.9 хувиар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагууд, 58.3 хувиар Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагууд, 56.8 хувиар Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагууд орж байна. Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудын дунджаар ашиг сонирхлын зөрчлийн эзлэх хувь 57.1 хувь байна. Баян-Өлгий (68.8 хувь), Архангай (67.9 хувь), Хөвсгөл (64.3 хувь), Говь-Алтай (62.5 хувь), Ховд (60.7 хувь), Говь-Алтай (62.5 хувь), Өмнөговь (60.0 хувь) аймгуудын нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудад ашиг сонирхлын зөрчил харьцангуй их тархсан гэж үзэж байгаа бол Төв (45.0 хувь), Дархан-Уул (46.4 хувь) аймгуудын нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудад ашиг сонирхлын зөрчил харьцангуй бага тархсан гэж үнэлэгджээ.

Салбарын үйл ажиллагааны эрх зүйн орчин нь авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх нөхцлийг бүрдүүлж чаддаг эсэх дээр нийт шинжээчдийн 3.5 хувь нь хангалттай сайн орчин бүрдсэн гэж үзсэн бол, 45.8 хувь нь боломжийн орчин гэж, 50.7 хувь нь хангалтгүй гэж үзжээ. салбар тус бүрийг үнэлж буй шинжээчдийн 33.3-61.5 хувь нь салбарын эрх зүйн орчинг авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд хангалттай бус гэж үзжээ. Зам

тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудын үнэлж буй шинжээчид уг салбаруудад авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх эрх зүйн орчин хамгийн хангалтгүй гэж үзэж байгаа бөгөөд шинжээчдийн 61.5-64.3 хувь нь хангалтгүй гэж үзжээ. Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудын хувь эрх зүйн орчин нь авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд хангалттай байдаг гэж 1.2 хувь нь үзсэн бол 42.5 хувь нь боломжийн орчин, 56.3 хувь хангалтгүй гэж үнэлжээ.

2.2.3 Салбарын бүтцийн шинжилгээ

Авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд салбарын удирдлагын болон албан хаагчдынх нь авлигатай тэмцэх гэсэн хүсэл зоригоос гадна салбарын бүтэц, тогтолцоо шууд нөлөөлдөг. Авлигатай тэмцэх үр дүнтэй тогтолцоо бүрдсэн эсэхийг судалгаанд оролцсон шинжээчид дараах байдлаар дүгнэжээ.

Салбарын бүтцийн шинжилгээнд бид бүхэн салбарын бүтэц тогтолцоо сайн засаглалын үндсэн шаардлагад нийцэж байгаа эсэх, шийдвэр гаргах үйл явцын нээлттэй байдал, байгууллагын дүрэм журмын нийцтэй байдал, авлигад өртөх эрсдлийн шинжилгээний ашиглалтын түвшин, салбарын ажилтан албан хаагчдыг томилох үйл ажиллагаа, тендер шалгаруулалт, санхүүгийн төлөвлөлт, зарцуулалтын нээлттэй байдлын шижилгээ зэргийг авч үзсэн. Түүнчлэн сайн засаглалын үндсэн шалгууруудад ил тод байдал, хариуцлага тооцдог механизмын нийцтэй байдал, шударга байдал зэргийг хамруулан авч үзсэн.

Төрийн байгууллагуудын бүтэц тогтолцоо сайн засаглалын ил тод байдлын шалгуурт тун сайн нийцдэг гэж шинжээчдийн 8.4 хувь нь, зарим талаараа нийцнэ гэж 66.0 хувь нь, огт нийцдэггүй гэж 22.2 хувь нь үзсэн бол мэдэхгүй гэж 3.5 хувь нь хариулжээ. Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын, Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн тал хувь нь салбарын бүтэц тогтолцоо нь ил тод байх шалгуурт огт нийцдэггүй гэж үзсэн нь хамгийн хаалттай салбарууд болж байна. Шинжээчдийн үнэлгээгээр хамгийн ил тод нээлттэй салбар нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын салбарууд орж байгаа бөгөөд эдгээр салбарыг үнэлж буй шинжээчдийн 86.7 хувь, 83.3 хувь нь тус тус салбарын бүтэц тогтолцоо нь ил тод байдлын шалгуурт ямар нэг байдлаар нийцдэг гэж үзжээ. Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын хувьд тогтолцоо нь ил тод байдлын шалгуурт огт нийцдэггүй аймгуудад Өмнөговь (60.0 хувь), Ховд (57.1 хувь), Архангай (42.9 хувь), Булган (40.0 хувь) аймгууд орж байна. Харин тогтолцоо нь ил тод байдлын шалгуурт зарим талаараа нийцнэ гэж шинжээчид бүгд, 100.0 хувь хариулсан Дорнод, Сүхбаатар аймгуудын нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагыг тогтолцооны хувьд харьцангуй нээлттэй байгууллагууд гэж үнэлж болох юм.

Төрийн байгууллагуудын бүтэц тогтолцоо сайн засаглалын хариуцлага тооцдог механизмын шалгуурт тун сайн нийцдэг гэж шинжээчдийн 11.0 хувь нь, зарим талаараа нийцнэ гэж 47.6 хувь нь, огт нийцдэггүй гэж 32.6 хувь нь үзсэн бол мэдэхгүй гэж 8.9 хувь нь хариулжээ. Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн 53.8

хувь нь, Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн тал хувь нь, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн 38.9 хувь нь, Сангийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн 38.5 хувь нь салбарын бүтэц тогтолцоо нь хариуцлага тооцдог механизмын шалгуурт огт нийцдэггүй гэж үзсэн нь хамгийн хариуцлагын тогтолцоо сул салбарууд болж байна. Шинжээчдийн үнэлгээгээр хамгийн хариуцлага тооцох тогтолцоо өндөртэй салбар нь Батлах хамгаалахын сайдын эрхлэх асуудлын, Шүүх, прокурорын байгууллага, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагууд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагууд, Шадар сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн 62.5 -100.0 хувь нь тус тус салбарын бүтэц тогтолцоо нь хариуцлага тооцдог механизмын шалгуурт ямар нэг байдлаар нийцдэг гэж үзжээ. Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын хувьд тогтолцоо нь хариуцлага тооцдог механизмын шалгуурт харьцангуй нийцдэггүй аймгуудад Орхон (80.0 хувь), Дархан-Уул (71.4 хувь), Өмнөговь (60.0 хувь), Архангай (57.1 хувь) аймгууд орж байна. Харин Говь-Алтай аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын тогтолцоо нь хариуцлага тооцдог механизмын шалгуурт зарим талаараа нийцнэ гэж шинжээчид бүгд үзсэн бол Дорнод, Сэлэнгэ, Говьсүмбэр аймгуудын шинжээчдийн 71.4-87.5 хувь нь нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагыг бүтэц тогтолцооны хувьд харьцангуй хариуцлага тооцох механизм сайтай гэж үнэлжээ.

Төрийн байгууллагуудын бүтэц тогтолцоо сайн засаглалын шударга байдлын шалгуурт тун сайн нийцдэг гэж шинжээчдийн 6.9 хувь нь, зарим талаараа нийцнэ гэж 47.8 хувь нь, огт нийцдэггүй гэж 45.0 хувь нь үзсэн бол мэдэхгүй гэж 0.3 хувь нь хариулжээ. Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн 75.0 хувь нь, Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн 61.5 хувь нь, Сангийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн 53.8 хувь нь, Хууль зүй, дотоодын хэргийн сайдын болон Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн тал хувь нь салбарын бүтэц тогтолцоо нь шударга байдлын шалгуурт огт нийцдэггүй гэж үзсэн нь хамгийн шударга бус бүтэц тогтолцоотой салбарууд болж байна. Шинжээчдийн үнэлгээгээр хамгийн шударга байдлын шалгуурт нийцдэг тогтолцоо бүхий салбар нь Шүүх, прокурорын байгууллага, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын, Батлах хамгаалахын сайдын эрхлэх асуудлын, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн 64.3 -85.7 хувь нь тус тус салбарын бүтэц тогтолцоо нь шударга байдлын шалгуурт ямар нэг байдлаар нийцдэг гэж үзжээ. Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын хувьд тогтолцоо нь шударга байдлын шалгуурт харьцангуй нийцдэггүй аймгуудад Баянхонгор (75.0 хувь), Хэнтий (75.0 хувь), Архангай (71.4 хувь), Хөвсгөл (71.4 хувь), Говь-Алтай (66.7 хувь), Дорноговь (62.5 хувь) аймгууд орж байна. Харин Сүхбаатар аймгийн нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын тогтолцоо нь шударга байдлын шалгуурт зарим талаараа нийцнэ гэж шинжээчид бүгд үнэлсэн бол Сэлэнгэ, Говьсүмбэр, Увс аймгуудын шинжээчдийн 71.4-75.0 хувь нь нутгийн

захиргааны болон өөрөө удирдах байгууллагыг бүтэц тогтолцооны хувьд харьцангуй шударга байдлын шалгуурт нийцдэг гэж үнэлжээ.

Салбарын хэмжээнд шийдвэр гаргахад гүйцэтгэх түвшний мэргэжлийн албан хаагчидтай зөвлөлдөн тэдний санал бодлыг тусгадаг эсэх талаарх асуултад нийт шинжээчдийн 11.0 хувь нь огт тусгадаггүй гэж хариулсан бол 71.5 хувь нь жижиг сажиг асуудал дээр асууж зөвлөлдөх нь бий гэж, 17.6 хувь нь бүх асуудлаар зөвлөлдөж тусгадаг гэж хариулжээ.

Төрийн захиргааны болон нутгийн захиргаа, удирдлагын байгууллагын дүрэм журманд шинжээчдээр дамжуулан байгууллагын дүрэм журам нь мэдээллийг ил тод байлгах, хүнд суртал төвлөрлийг бууруулах, хөндлөнгийн хяналт мониторинг хийх, эрсдэл бүхий албан тушаалын сэлгээ хийх, албан хаагчдын зүй бус үйлдлийн талаар иргэдээс мэдээлэл авах нөхцлийг хангадаг эсэхэд шинжилгээ хийсэн юм. Судалгааны дүнгээс харахад судалгаанд хамрагдсан салбаруудын дунджаар байгууллагын дүрэм журам нь мэдээллийг ил тод байлгах нөхцлийг 19.0 хувь нь хангалттай сайн хангана гэж үзсэн бол 65.4 хувь нь зарим талаараа хангана, 12.7 хувь нь огт хангадаггүй гэж үзжээ. Шинжээчдийн үзэж байгаагаар дүрэм журам нь мэдээллийг ил тод байлгах нөхцлийг харьцангуйгаар сайн хангаж чаддаггүй салбаруудад Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын (шинжээчдийн 30.8 хувь нь огт хангадаггүй гэж үзсэн), Сангийн сайдын эрхлэх асуудлын (шинжээчдийн 23.1 хувь нь огт хангадаггүй гэж үзсэн) болон Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын (шинжээчдийн 21.4 хувь нь огт хангадаггүй гэж үзсэн) төрийн байгууллагууд орж байна. Аймаг, нийслэлийн нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудаас Ховд аймгийн (шинжээчдийн 57.1 хувь нь огт хангадаггүй гэж үзсэн), Баян-Өлгий аймгийн (шинжээчдийн 37.5 хувь нь огт хангадаггүй гэж үзсэн) болон Сэлэнгэ аймгийн (шинжээчдийн 28.6 хувь нь огт хангадаггүй гэж үзсэн) нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудын дүрэм журам нь мэдээллийг ил тод байлгах нөхцлийг харьцангуй бүрдүүлж чаддаггүй байна.

Нийт үнэлж буй салбаруудын дунджаар шинжээчдийн 13.3 хувь нь салбарын дүрэм журам нь хүнд суртал, төвлөрлийг бууруулах нөхцлийг хангалттай сайн хангадаг гэж үзсэн бол 51.3 хувь нь зарим талаараа хангана, 30 хувь нь огт хангадаггүй гэж үзэж, 5.5 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Салбарын дүрэм журам нь хүнд суртал, төвлөрлийг бууруулах нөхцлийг огт хангадаггүй гэж Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын салбарыг үнэлсэн шинжээчдийн 46.2 хувь нь, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын салбарыг үнэлж буй шинжээчдийн 40.0 хувь нь, Шадар сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн 37.5 хувь нь, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын салбарыг үнэлсэн шинжээчдийн 36.4 хувь нь үнэлсэн нь эдгээр салбарууд нь харьцангуй дүрэм журмаараа хүнд суртал оршин байх нөхцлийг бүрдүүлээд байна гэдгийг анхаарч үзэх хэрэгтэй. Харин нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудын дунджаар шинжээчдийн 7.8 хувь нь дүрэм журам нь хүнд суртал төвлөрлийг бууруулах нөхцлийг хангалттай сайн хангадаг гэж үзсэн бол 52.7 хувь нь зарим талаараа хангана, 33.5 хувь нь огт хангадаггүй гэж үзжээ. Булган аймгийг үнэлсэн шинжээчдийн 60.0 хувь нь, Баянхонгор, Говь-Алтай, Завхан аймгуудыг үнэлсэн шинжээчдийн тал хувь нь байгууллагын дүрэм журам нь хүнд суртал, төвлөрлийг бууруулах нөхцлийг огт

хангадаггүй гэж үзсэн нь анхаарлаа хандуулах шаардлагатай үзүүлэлт болж байна.

Авлигаас урьдчилан сэргийлэхэд хөндлөнгийн хяналт чухал үүрэгтэй байдаг. Судалгаанд оролцсон шинжээчдийн 12.7 хувь нь салбарын дүрэм журам нь хөндлөнгийн хяналт мониторинг хийх нөхцлийг хангалттай сайн хангасан гэж үзэж байгаа бол 48.7 хувь нь зарим талаараа хангана, 28.2 хувь нь огт хангадаггүй гэж үнэлжээ. Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлсэн шинжээчдийн тал хувь нь, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлсэн шинжээчдийн 38.9 хувь нь, Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлсэн шинжээчдийн 38.5 хувь нь, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлсэн шинжээчдийн 30.8 хувь нь салбарын дүрэм журам нь хөндлөнгийн хяналт хийх нөхцлийг огт хангадаггүй гэж үзэж байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт болж байна.

Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудын дунджаар шинжээчдийн 9.0 хувь нь байгууллагын дүрэм журам нь хөндлөнгийн хяналт хийх нөхцлийг сайн хангадаг гэж үзсэн бол 49.1 хувь нь зарим талаараа хангадаг, 32.3 хувь нь огт хангадаггүй гэж үзжээ. Байгууллагын дүрэм журам нь хөндлөнгийн хяналт хийх нөхцлийг огт хангадаггүй гэж Ховд аймгийг үнэлсэн шинжээчдийн 71.4 хувь нь, Архангай, Булган, Өвөрхангай, Сэлэнгэ, Хэнтий, Орхон аймгийг үнэлсэн шинжээчдийн 50.0-60.0 хувь нь үзсэн нь хөндлөнгийн хяналтын тогтолцоо харьцангуй алдагдсан гэж үзэж болохоор байна.

Эрсдэл бүхий албан тушаалын сэлгээ хийх нөхцлийг дүрэм журам нь огт хангадаггүй гэж нийт шинжээчдийн 41.8 хувь нь үзсэн бол 32.0 хувь нь зарим талаараа хангана, 6.1 хувь нь хангалттай сайн хангана гэж үзжээ. Шүүх прокурорын байгууллага, Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын төрийн байгууллагуудад эрсдэл бүхий албан тушаалтны сэлгээ хийх нөхцөл дүрэм журманд харьцангуй сайн тусгагдсан байдаг байна. Дээр дурдсан салбарыг үнэлсэн шинжээчдийн 14.3-28.6 хувь нь салбарын дүрэм журам нь эрсдэл бүхий албан тушаалын сэлгээ хийх нөхцлийг хангалттай сайн хангана гэж үзжээ. Харин эрсдэл бүхий албан тушаалын сэлгээ хийх нөхцөл хангалтгүй салбаруудад Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагууд орж байна. Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудын дунджаар шинжээчдийн 15.3 хувь нь байгууллагын дүрэм журам нь эрсдэл бүхий албан тушаалын сэлгээ хийх нөхцлийг сайн хангадаг гэж үзсэн бол 29.9 хувь нь зарим талаараа хангадаг, 44.9 хувь нь огт хангадаггүй гэж үзжээ.

Албан хаагчдын зүй бус үйлдлийн талаарх мэдээлэл авах нөхцлийг дүрэм журам нь огт хангадаггүй гэж нийт шинжээчдийн 32.3 хувь нь үзсэн бол 40.3 хувь нь зарим талаараа хангана, 15.3 хувь нь хангалттай сайн хангана гэж үзжээ.

Энэ бүхнээс салбаруудын дүрэм журам нь харилцан адилгүй байдаг авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр салбаруудын дүрэм журмыг хянан үзэж, дээр дурдсан нөхцлүүдийг бүрдүүлсэн дүрэм журмыг боловсруулах шаардлага гэсэн дүгнэлтийг хийж байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хамгийн чухал хэсэг нь судалгаа шинжилгээний ажил юм. Үнэлж буй салбаруудын дунджаар нийт шинжээчдийн 70.6 хувь нь салбарын бүтцийн нэгжүүдийн авлигад өртөх эрсдлийн шинжилгээ болон онцгой анхаарах чиглэлийн талаархи үнэлгээ байдаггүй гэж үзсэн бол 27.1 хувь нь хагас дутуу хийсэн зүйл байдаг гэж үзжээ. Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудын хувьд шинжээчдийн 74.9 хувь нь ийм зүйл байхгүй гэж үзжээ. Түүнчлэн үнэлж буй салбаруудын дунджаар нийт шинжээчдийн 40.9 хувь нь зарим нэг тохиолдолд салбарын хэмжээнд авлигын талаар судалгаа, шинжилгээ хийж, энэ чиглэлээр хийгдэж байгаа судалгаа шинжилгээг тоймлон үзэж үйл ажиллагааны төлөвлөлтөд харгалзан үздэг гэж үзсэн бол, 57.3 хувь ийм зүйл огт байдаггүй гэж үзжээ. Тэгэхээр энэ чиглэлийн судалгаа шинжилгээний ажил салбаруудын хэмжээнд бараг хийгддэггүй, судалгаа шинжилгээний үр дүнг үйл ажиллагаандаа огт авч ашигладаггүй гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна.

Нийт үнэлж буй салбаруудын дүнгээр ажилтан, албан хаагчдыг шинээр ажилд авах, ажлаас халах, албан тушаал дэвшүүлэх, шагнаж урамшуулах зэрэг боловсон хүчинтэй холбоотой үйл ажиллагаа, шийдвэр нь ил тод шударга хийгддэг гэж нийт шинжээчдийн 12.4 хувь нь үнэлсэн бол 44.9 хувь нь зарим тохиолдолд ил тод, шударга явагддаг, 45.5 хувь нь огтхон ч ил тод, шударга биш гэж үзжээ. Боловсон хүчинтэй холбоотой асуудалд хамгийн хаалттай салбаруудад Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагууд орж байгаа бөгөөд салбарыг үнэлсэн шинжээчдийн 51.1-59.4 хувь нь боловсон хүчинтэй холбоотой үйл ажиллагаа огтхон ч ил тод, шударга явагдаггүй гэж үзжээ.

Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудын дунджаар шинжээчдийн 7.6 хувь нь боловсон хүчинтэй холбоотой үйл ажиллагаа, шийдвэр ил тод, шударга явагддаг гэж үзсэн бол 45.5 хувь нь зарим тохиолдолд ил тод, шударга явагддаг, 39.1 хувь нь огтхон ч ил тод, шударга явагддаггүй гэж үзжээ. Боловсон хүчний асуудалд хамгийн хаалттай, шударга бус ханддаг нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагад Хөвсгөл (шинжээчдийн 82.1 хувь нь огтхон ил тод, шударга ханддаггүй гэж үзсэн), Архангай (шинжээчдийн 64.3 хувь нь огтхон ил тод, шударга ханддаггүй гэж үзсэн), Өмнөговь (шинжээчдийн 60.0 хувь нь огтхон ил тод, шударга ханддаггүй гэж үзсэн), Говь-Алтай (шинжээчдийн 54.2 хувь нь огтхон ил тод, шударга ханддаггүй гэж үзсэн), Дундговь, Ховд, Орхон (шинжээчдийн 50.0 хувь нь огтхон ил тод, шударга ханддаггүй гэж үзсэн) аймгуудын нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагууд орж байна. Харин Төв аймгийг үнэлсэн шинжээчдийн 60.0 хувь нь боловсон хүчний асуудал ил тод, шударга явагддаг гэж үзсэн нь хамгийн сайн үзүүлэлт болж байна.

Тендер шалгаруулалт буюу төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны сонгон шалгаруулалтыг үнэлж буй салбаруудын дүнгээр нийт шинжээчдийн 9.2 хувь нь ил тод шударга хийгддэг гэж үзсэн бол 27.1 хувь нь зарим тохиолдолд ил тод, шударга явагддаг, 47.8 хувь нь огтхон ч ил тод, шударга явагддаггүй гэж үзжээ. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн 61.1 хувь нь, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй

шинжээчдийн 57.1 хувь нь, нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагыг үнэлж буй шинжээчдийн 56.3 хувь нь, Сангийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн 53.8 хувь нь тендер шалгаруулалт тус салбарт огтхон ч ил тод, шударга явагддаггүй гэж хариулсан нь тендер шалгаруулалт хамгийн шударга бус, хаалттай явагддаг салбарууд болж байна. Нутгийн захиргааны байгууллагууд дотроос Баян-Өлгий аймгийг үнэлж буй шинжээчид бүгд буюу 100.0 хувь, Өмнөговь, Орхон аймгуудыг үнэлж буй шинжээчдийн 80.0 хувь нь, Өвөрхангай аймгийг үнэлж буй шинжээчдийн 75.0 хувь нь, Ховд, Хөвсгөл, Дархан-уул, Говьсүмбэр аймгуудыг үнэлж буй шинжээчдийн 71.4 хувь нь тендер шалгаруулалт огтхон ч ил тод, шударга явагддаггүй гэж үзсэн нь тендер шалгаруулалтыг хамгийн хаалттай, шударга бус явуулдаг нутгийн захиргааны байгууллагууд болж байна.

Үнэлж буй салбаруудын дүнгээр нийт шинжээчдийн 11.5 хувь нь санхүүгийн тайлан тооцоо, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын үйл ажиллагаа ил тод, шударга явагддаг гэж үзсэн бол 40.3 хувь нь зарим тохиолдолд ил тод, шударга явагддаг, 32.0 хувь нь огтхон ч ил тод, шударга явагддаггүй гэж үзжээ. уг үзүүлэлтийг салбаруудаар авч үзвэл онцгой ялгарах байдал байхгүй, нийтлэг байдалтай байна.

Түүнчлэн үнэлж буй салбаруудын дүнгээр худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт авлига, хээл хахуульд автсан гэдэгтэй шинжээчдийн 32.9 хувь нь санал бүрэн нийлж байна гэж хариулсан бол 57.1 хувь нь зарим талаараа санал нийлж байна, 10.1 хувь огт нийлэхгүй байна гэж үзжээ. Уг асуудалтай санал бүрэн нийлж байна гэж хариулсан шинжээчдийн эзлэх хувь Сангийн сайдын эрхлэх асуудлын (46.2 хувь), Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын (46.2 хувь), Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын, Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын (38.9 хувь) төрийн байгууллагад харьцангуй өндөр байна. Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудын хувьд Булган (шинжээчдийн 80.0 хувь), Баян-Өлгий (шинжээчдийн 75.0 хувь), Архангай, Хөвсгөл (шинжээчдийн 71.4 хувь), Орхон (шинжээчдийн 60.0 хувь) аймгуудын нутгийн захиргааны байгууллагуудын тендер шалгаруулалт харьцангуй их авлига, хээл хахуульд автсан гэж үнэлэгджээ.

Нийт шинжээчдийн үзэж байгаагаар үнэлэгдэж буй салбаруудын хэмжээнд хэрэгжүүлж төсөл хөтөлбөрийн дунджаар 10.11 хувь нь авлига, хээл хахуультай холбоотойгоор зарцуулагддаг байна. Уг үзүүлэлт Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудад 13.5 хувь, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудад 12.5 хувь, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудад 11.9 хувь байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт болж байна.

Нийт шинжээчдийн үзэж байгаагаар үнэлэгдэж буй салбаруудын хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан үйл ажиллагаанд гэрээний үнийн дүнгийн дунджаар 10.45 хувь нь авлига, хээл хахуультай холбоотойгоор зарцуулагддаг байна. Уг үзүүлэлт Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудад 14.6 хувь, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын төрийн

байгууллагуудад 12.5 хувь, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудад 11.8 хувь, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудад 11.0 хувь байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт болж байна.

Сангийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудын хүрээнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхэд нийт үнийн дүнгийн дунджаар 11.7 хувь нь авлига, хээл хахуульд зарцуулагддаг гэж тус салбарыг үнэлж буй шинжээчид үзжээ. Жишээлбэл, 100.0 сая төгрөгийн татварыг чөлөөлүүлэхийн тулд 11.7 сая төгрөгийг хээл хахууль болгон зарцуулдаг гэж үзжээ.

2.2.4 Ажилтан албан хаагчдын шударга байдлын шинжилгээ

Төрийн байгууллагын ажилтан албан хаагчдын шударга байдлыг нарийвчилан зохицуулах эрх зүйн баримт бичгийн нэг нь ёс зүйн дүрэм байдаг. Сүүлийн жилүүдэд энэхүү дүрмийг бүх төрийн байгууллагад баталж мөрдүүлэх ажил эрчимжиж байна. Үнэлж буй салбаруудын дүнгээр нийт шинжээчдийн 76.7 хувь нь салбарт ажилтан албан хаагчдын ёс дүрэм байдаг гэж хариулсан бол 23.3 хувь нь байдаггүй гэж хариулжээ. Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудын хувьд шинжээчдийн 73.7 хувь нь нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагууд ёс зүйн дүрэмтэй болсон гэж үзжээ. Энд мөн ажилтан албан хаагчдын ёс зүйн дүрэм байдаг хэдий ч харилцагч байгууллагынхан нь мэддэггүйн улмаас ёс дүрэм байдаггүй гэж үнэлэгдсэн байх талтайг анхаарч үзэх хэрэгтэй.

Ёс зүйн дүрмэнд авлигатай холбоотой тун тодорхой заалтууд байдаг гэж шинжээчдийн 36.5 хувь нь үзсэн бол 57.1 хувь нь ерөнхий ганц нэг заалт бий, 6.4 хувь нь огт байдаггүй гэж дүгнэжээ.

Салбарын албан хаагчид нь ашиг сонирхлоо албан ёсоор бичгээр мэдэгддэг журамтай гэж нийт шинжээчдийн 8.1 хувь нь хариулсан бол 36.6 хувь нь зарим тохиолдолд бичгээр бус амаар хэлэх нь бий, 55.3 хувь нь ашиг сонирхлын зөрчлөө огтхон ч мэдүүлдэггүй гэж хариулжээ. Ер нь ашиг сонирхлын зөрчлөө мэдүүлэх явдал салбаруудын түвшинд хангалтгүй байгаа

бөгөөд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн 80.0 хувь нь, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн 71.4 хувь нь ашиг сонирхлын зөрчлөө огтхон ч мэдүүлдэггүй гэж үзжээ.

Үнэлж салбаруудын дүнгээр албан хаагчдын дунд авлигаас урьдчилан сэргийлэх сургалт, семинар хангалтгүй хийгддэг, тэдгээр үр өгөөж муутай байдаг гэж шинжээчид үнэлж байна. Нийт шинжээчдийн ердөө 6.3 хувь нь ийм төрлийн сургалт семинар байнга хийгддэг бөгөөд, үр өгөөж сайтай байдаг гэж үзсэн бол 64.6 хувь хааяа нэг хийгддэг бөгөөд үр өгөөж муутай байдаг, 29.1 хувь нь ийм сургалт семинар огт хийгддэггүй гэж үзжээ. Төрийн захиргааны байгууллагуудын түвшинд, түүнчлэн нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын түвшинд нөхцөл байдал адилхан байна.

Тухайн салбарын албан хаагчид авлига хээл хахуулийг хэрхэн үнэлэн ярилцдаг вэ гэсэн асуултад судалгаанд хамрагдсан шинжээчид гурван тэнцүү бүлэгт хуваагдаж байна. Нийт шинжээчдийн 33.7 хувь нь салбарын албан хаагчид нь авлига, хээл хахуулийг байдаг л зүйл гэж ярилцдаг гэж үзсэн бол 32.6 хувь нь зайлшгүй тохиолдолд байх ёстой зүйл гэж үзэх нь түгээмэл, 33.7 хувь нь огт байж болохгүй сөрөг үзэгдэл гэж үздэг. Өөрөөр хэлбэл, шинжээчид төрийн албан хаагчдын гурван хүний нэг нь авлига, хээл хахуулийг байдаг л зүйл үздэг гэж дүгнэжээ. Тэгэхээр ардчилсан засаглалыг бэхжүүлж, авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгох зорилтыг тавин ажиллаж буй бидний хувьд төрийн албан хаагч нэг бүрийн сэтгэлгээг өөрчлөх томоохон шалгуур зорилт байна гэдгийг ойлгож ухамсарлах нь зүйтэй юм.

Төрийн албан хаагчдын цалин хөлс хангалтгүй байдгаас өөрийн албан чиг үүрэгтэй ижил төстэй өөр ажил эрхэлж нэмэлт орлого олох нь байдаг. Энэ хэмжээгээр ашиг сонирхлын зөрчил үүсэх, өөрт олгогдсон албан эрх мэдлийг хувийн ашиг хонжоо олоход ашиглах явдал нэмэгддэг. Үнэлж буй салбаруудын дүнгээр нийт шинжээчдийн 17.9 хувь нь ийм ажил эрхлэх нь түгээмэл зүйл гэж үзсэн бол 56.2 хувь нь байдаг, гэхдээ ховор, 25.9 хувь нь огт байдаггүй гэж үзэж болно гэж хариулжээ. Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн 62.5 хувь нь, Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн 55.6 хувь нь ийм ажил эрхлэх нь түгээмэл зүйл гэж хариулжээ.

Албан хаагчдын хувьд ажил хэргийн холбоотой байгууллага, иргэдтэй холбоотой хувийн харилцаа ихэд тархсан ердийн үзэгдэл гэж нийт шинжээчдийн 33.7 хувь нь үзсэн бол 60.5 хувь нь ийм зүйл ажиглагддаг гэхдээ төдийлөн тархаагүй, 5.8 хувь нь ийм харилцаа байдаггүй гэж үзжээ. Албан хаагчдынх нь дунд ажил хэргийн холбоотой байгууллага, иргэдтэй тогтоосон хувийн харилцаа ихээхэн тархсан салбаруудад Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагууд (шинжээчдийн 75.0 хувь нь ингэж үзсэн), Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагууд (шинжээчдийн 57.1 хувь нь ингэж үзсэн), Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагууд (шинжээчдийн 54.5 хувь нь ингэж үзсэн), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагууд (шинжээчдийн 50.0 хувь нь ингэж үзсэн) орж

байна. Баян-Өлгий, Баянхонгор, Өмнөговь, Хөвсгөл аймгуудын нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудын хувьд албан хаагчид нь ажил хэргийн холбоотой байгууллага, иргэдтэй хувийн харилцаатай байх нь хамгийн түгээмэл байдаг байна. Эдгээр байгууллагыг үнэлсэн шинжээчдийн 60.0-75.0 хувь нь уг байдлыг албан хаагчдын дунд ихэд тархсан ердийн үзэгдэл гэж үзжээ.

Авлига нь бэлэг дурсгалын зүйл авахаас эхэлдэг. Иймд бэлэг, дурсгалын зүйл авах асуудлыг оновчтой зохицуулах зүйтэй. Албан хаагчдын хувьд албан үүргийн дагуу харилцаж байгаа хувь хүн, байгууллагаас бэлэг дурсгал авахыг зохицуулсан зохицуулалт байдаггүй нийт шинжээчдийн 72.9 хувь нь хариулсан бол 27.1 хувь үнийн дүнтэй уялдуулсан зохицуулалт байдаг гэж хариулжээ. Сангийн сайдын эрхлэх асуудлын салбарыг үнэлж буй шинжээчдийн 61.5 хувь нь үнийн дүнтэй уялдуулсан зохицуулалт байдаг гэж хариулсан бол Шадар сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн 87.5 хувь ийм зохицуулалт байдаггүй гэж хариулжээ.

Төрийн албан хаагчдыг авлигаас урьдчилан сэргийлэх, тэдний зохистой зан үйлийг төлөвшүүлэх үүднээс шударга байдлын гэрээ байгуулдаг туршлага байдаг хэдий ч энэ асуудал манай улсын хувьд төдийлөн нийтлэг бус зүйл юм. Судалгаанд хамрагдсан шинжээчдийн 92.2 хувь нь албан хаагчид шударга байдлын гэрээ байгуулдаггүй гэж хариулжээ.

2.2.5 Салбарын /байгууллагын авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны шинжилгээ

Салбарын хүрээнд авлигатай тэмцэх өдөр, сарын кампанит ажил зохион байгуулах явдал мөн төдийлөн нийтлэг зүйл болж чадаагүй байна. Нийт шинжээчдийн 1.7 хувь нь л ийм төрлийн арга хэмжээг байнга зохион байгуулдаг гэж хариулсан бол 39.5 хувь нь хааяа нэг зохиох нь бий, 58.8 хувь нь зохиодоггүй гэж хариулжээ. Нутгийн захиргааны байгууллагуудын түвшинд нөхцөл байдал ижил түвшинд байна.

Салбарын чиг үүргийг олон нийтэд тайлбарлан таниулдаг, салбарын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл ил тод хүртээмжтэй, иргэдийн гомдол саналыг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагаа нь тодорхой байх нь авлига, хүнд суртал үүсэхээс урьдчилан сэргийлэхэд чухал үүрэгтэй. Нийт шинжээчдийн 32.9 хувь нь салбарын чиг үүргийг олон нийтэд тайлбарлан таниулах арга хэмжээг хангалттай сайн төлөвлөн хэрэгжүүлдэг гэж үзсэн бол 46.4 хувь нь дунд зэрэг, 18.2 хувь нь хангалтгүй гэж үнэлжээ. Энэ чиглэлийн ажлыг хангалттай сайн хэрэгжүүлдэг салбаруудад Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын (66.7 хувь), Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын (50.0 хувь) төрийн байгууллагууд орж байна. Харин аймгуудаас Дорнод (87.5 хувь), Төв (40.0 хувь), Увс, Баян-Өлгий (37.5 хувь), түүнчлэн нийслэл Улаанбаатар хот

(35.0 хувь)-ын нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагууд энэ чиглэлийн ажлыг хангалттай сайн хэрэгжүүлдэг гэж үнэлэгджээ.

Нийт шинжээчдийн дунджаар 32.9 хувь нь салбарын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хангалттай сайн ил тод хүртээмжтэй гэж үзсэн бол 46.4 хувь нь дунд зэрэг, 18.2 хувь нь хангалтгүй гэж үнэлжээ. Түүнчлэн нийт шинжээчдийн дунджаар 30.5 хувь нь салбарын хэмжээнд иргэдийн гомдол саналыг хүлээн авах, барагдуулах үйл ажиллагаа нь хангалттай сайн гэж үзсэн бол 45.8 хувь нь дунд зэрэг, 17.6 хувь нь хангалтгүй гэж үнэлжээ. Энэ асуудал Шүүх, прокурорын байгууллагууд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудад харьцангуй сайн гэж үнэлэгдэж байгаа бол Сангийн сайдын, Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын болон Шадар сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудад хангалтгүй байдаг гэж үнэлжээ. Нутгийн захиргааны байгууллагуудаас Төв аймаг харьцангуй хангалттай сайн гэж үнэлсэн бол Говь-Алтай, Хөвсгөл аймгуудад харьцангуй хангалтгүй гэж үнэлжээ.

Харин салбарын хэмжээнд ирсэн гомдлын мөрөөр авсан арга хэмжээг иргэдэд эргэн танилцуулах талаарх хангалттай сайн гэсэн үнэлгээг Шадар сайдын эрхлэх асуудлын (50.0 хувь), Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын (40.0 хувь) төрийн байгууллагууд болон Увс (37.5 хувь), Дорнод (28.6 хувь) аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудад шинжээчид өгчээ.

Тухайн салбарын үйл ажиллагааг түргэн шуурхай, ил тод явуулах, мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангах үүднээс мэдээллийн технологийн ололтыг ашиглах нь хүнд суртлыг багасгах, мэдээллийг цаг хугацаа, орон зайгаас үл хамааран авах боломжийг бүрдүүлдэгээрээ ач холбогдолтой. Энэ чиглэлээр хангалттай сайн ажиллаж байна гэж нийт шинжээчдийн 23.6 хувь нь үнэлсэн бол 42.4 хувь нь дунд зэрэг, 28.5 хувь нь хангалтгүй гэж үнэлжээ.

2.2.6 Авлигатай тэмцэх ажлын эрх зүйн зохицуулалтын болон хамтын ажиллагааны шинжилгээ

Нийт үнэлж буй салбаруудын ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчдад авах захиргааны арга хэмжээний дүрэм журам байдаг гэж шинжээчдийн 79.3 хувь нь хариулжээ. Харин ёс зүйн асуудал хариуцсан нэгж салбарын хэмжээнд ажилладаг эсэх талаарх асуултад 42.4 хувь нь байдаг гэж хариулжээ. Харин нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын хувьд шинжээчдийн 38.3 хувь нь ёс зүйн асуудал хариуцсан нэгж байдаг гэж хариулжээ. Энд төрийн албаны салбар зөвлөл аймгийн засаг даргын газарт ажилладагийг хамруулан авч үзэж байх талтай юм.

Авлигатай холбоотой мэдээллийг АТГ-т нэн даруй хүргүүлэн, хуулийн дагуу шалгуулан тогтоолгосноор олон нийтийн дунд авлигын талаарх бодит бус мэдээлэл тарж, олон нийтийг бухимдуулахгүй байхад ач холбогдолтой. Түүнчлэн авлигатай холбоотой мэдээлэл нь хэн нэгийг дарамтлах, нэр хүндийг нь гутаахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т энэ талаарх мэдээллийг нэн даруй АТГ-т мэдээлнэ гэж заасан байдаг. Энэхүү чиг үүргийг төрийн байгууллагаас хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар шинжээчид дараах байдлаар үнэлж байна. Үнэлж буй төрийн

байгууллагуудын хэмжээнд 60.5 хувь нь авлигатай холбоотой мэдээллийг АТГ-т хүргүүлж, шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь гаргаж өгдөггүй гэж шинжээчид үнэлжээ.

Салбарын хэмжээнд хийгдэж буй аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх зүйл заалт оруулдаг гэж нийт шинжээчдийн 5.8 хувь нь үзсэн бол 41.2 хувь нь зарим тохиолдолд оруулдаг, 53.0 хувь нь оруулдаггүй гэж үзжээ. Шинжээчид батлан хамгаалахын салбарт байгуулж буй гэрээ хэлэлцээрт авлигатай холбоотой зүйл заалт огт оруулдаггүй гэж үзсэн бол Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын болон Шадар сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн 68.8 болон 73.3 хувь нь энэ төрлийн зүйл заалтыг тухайн салбарт байгуулж буй гэрээ хэлэлцээрт огт оруулдаггүй гэж үзжээ.

Нутгийн захиргааны байгууллагуудын түвшинд байгуулж буй гэрээ хэлэлцээрт авлигатай холбоотой зүйл заалт оруулах явдал харьцангуй хангалтгүй байдаг гэж үнэлэгджээ. Шинжээчдийн 43.7 хувь нь зарим тохиолдолд оруулдаг гэж хариулсан бол 54.5 хувь нь оруулдаггүй гэж хариулжээ.

Нийт шинжээчдийн 57.6 хувь үнэлж буй салбарын хэмжээнд авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр АТГ-тай хамтран ажилладаг, 48.7 хувь нь хууль хяналтын байгууллагуудтай, 38.0 хувь нь судалгаа, шинжилгээний байгууллагуудтай, 36.9 хувь нь иргэний нийгмийн байгууллагуудтай, 8.4 хувь нь олон улсын байгууллагуудтай хамтран ажилладаг гэж үзжээ.